

**Засгийн газрын үйл ажиллагааны
явцын талаарх 5 сарын хураангуй мэдээлэл**

Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын
Хяналт, Шинжилгээ, Үнэлгээ, Дотоод Аудитын газар

I. ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ:

A. Эдийн засгийн суурь үзүүлэлтийн мэдээлэл

	Төрөл	3 сар	4 сар	5 сар	Өсөлт/ Бууралт
1	Инфляци	3.6 %	4.8 %	-	1.2 % ↑
2	Ажилгүйдэл	53.9 мянга	37.6 мянга	-	30.3 % ↓
3	Мөнгөний нийлүүлэлт	7293.7(тэрбум.төг)	7197.5 (тэрбум.төг)	-	96.2 (тэрбум.төг) ↓
4	Экспортын хэмжээ	809.2 (сая.доллар)	1212.5 (сая.доллар)	-	403.3 (сая.доллар)↑
5	Импортын хэмжээ	1205.9 (сая.доллар)	1740.8 (сая.доллар)	-	534.9 (сая.доллар)↑
6	Бодлогын хүү	11.5 %	11.5 %	11.5 %	-
7	Валютын ханш (USD, CNY, EUR)	1404.39	1417.41	1438.27	+20.86 ↑(төг)
		225.95	229.12	234.21	+5.09 ↑(төг)
		1819.78	1843.72	1867.91	+24.19 ↑(төг)

Эх сурвалж: YCX; www.nso.mn; www.mongolbank.mn

B.Экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнийн мэдээлэл

	Төрөл	3 сар	4 сар	5 сар	Өсөлт/ Бууралт	
1	Алт (ам.доллар)	1591.01	1485.9	1416.14	-69.7 ↓	
2	Зэс (ам.доллар)	8070.00	7661.58	7202.57	-459.0 ↓	
3	Нүүрс (ам.доллар/тн)	4000 ккал хүртэл	-	36.5	30.74	-5.76 ↓
		4000-5000 ккал	-	54.2	55.78	+1.58 ↑
		Коксжих	-	101.9	105.98	+4.08 ↑
4	Төмөрийн хүдэр (ам.доллар/тн)	Бүхэллэг хүдэр	-	130.95	127.33	-3.62 ↓
		Нунтаг хүдэр	-	125.29	121.62	-3.67 ↓

Эх сурвалж: Уул уурхайн яам; www.mm.gov.mn; www.lme.com

B.Өргөн хэрэглээний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн мэдээлэл (төг)

	Төрөл	3 сар	4 сар	5 сар	Өсөлт/ Бууралт
1	Мах /үхэр	8500	8900	9014	+114 ↑ (төг)
2	Мах/хонь	7743	8088	8370	+282 ↑ (төг)
3	Талх	815	818	825	+7 ↑ (төг)
4	Гурил /дотоод	711	715	718	+3 ↑ (төг)
5	Элсэн чихэр	1725	1740	1661	-79 ↓ (төг)
6	Сүү	1768	1740	1734	-6 ↓ (төг)
7	Төмс	1060	1020	990	-30 ↓ (төг)
8	Бензин (АИ92)	1670	1670	1670	-
9	Дезиль	1800	1800	1800	-

Эх сурвалж: YCX; www.nso.mn

II. САНХҮҮ, ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР :

- Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2013 оны 4 дүгээр сарын гүйцэтгэлээр 1,589.4 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 10.5 хувиар буюу 186.9 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн бол нэгдсэн төсвийн нийт зарлага 2013 оны 4 дүгээр сарын байдлаар 2,002.5 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 1,453.4 тэрбум төгрөгийн буюу 72.6 хувийн, улсын төсвийн зарлага 1,651.2 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 1,150.1 тэрбум төгрөгийн буюу 69.7 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар нийт 1,550.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс оны эхний 3 сарын байдлаар 271.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр батлагдсан. Эхний улирлын байдлаар 35.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн нь батлагдсан сар, улирлын дүнтэй харьцуулахад 13 хувьтай, оны нийт төлөвлөгөөтэй харьцуулахад **2.3 хувьтай байгаа нь 2006 оноос хойшхи хамгийн муу үзүүлэлт юм.**
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний батлагдсан сар, улирлын хуваарийн дагуу эхний 3 сард санхүүжигдэхээр төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн байдалд судалгаа хийж үзэхэд **236.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээ авч чадаагүй 584 төсөл, арга хэмжээ байна.**
- 2013 оны 5 дугаар сарын 13-ны байдлаар төсөл, арга хэмжээний хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

НИЙТ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 546.8 тэрбум төгрөгийн 442 төсөл он дамжин хэрэгжих, 102.5 тэрбум төгрөгийн 176 төслийн эрх шилжүүлсэн, 153.8 тэрбум төгрөгийн 79 төслийг хэрэгжүүлэхээр гэрээ хийгдсэн, 14.2 тэрбум төгрөгийн 15 төсөлд үнэлгээ хийгдсэн, 221.9 тэрбум төгрөгийн 151 төслийн тендер зарлагдсан, 324.8 тэрбум төгрөгийн 208 төсөлд үнэлгээний хороо байгуулагдсан, 118.6 тэрбум төгрөгийн 80 төслийн тендерийн баримт бичиг, зураг төсөв боловсруулагдаж байгаа, 10.2 тэрбум төгрөгийн 10 төсөл одоогийн байдлаар зураг, төсвийн зөвлөх үйлчилгээ зарласан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн хувьд дараахь асуудлууд тулгамдаж байна. Үүнд:

1. Нийт төслийн 17.8% буюу 324.7 тэрбум төгрөгийн санхүүжилттэй 208 төслийн үнэлгээний хороо байгуулагдсан, тендер хараахан зарлагдаагүй байна.
2. Нийт төслийн 6.9% буюу 118.6 тэрбум төгрөгийн санхүүжилттэй 80 төсөл, арга хэмжээний тендерийн бичиг баримт болон зураг төсөв боловсруулагдаж байна.
3. Нийт төслийн 0.8% буюу 9.9 тэрбум төгрөгийн санхүүжилттэй 9 төсөл, арга хэмжээний зураг, төсвийн боловсруулалт эхлэлийн байдалтай байна.

- Хөгжлийн банк нь 2013 оны 5-12 саруудад Чингис бондын хөрөнгөөр Улсын төсвөөс эргэн төлөгдөх авто зам, дэд бүтэц, цахилгаан станц, төмөр зам болон Төслийн орлогоос эргэн төлөгдөх техник тоног төхөөрөмжийг шинэчлэх зэрэг 154 төсөлд нийт 1.5 их наяд төгрөгийн санхүүжилт олгох төлөвлөгөөтэй ажиллаж байна.

III. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

А. Замын бүтээн байгуулалт:

- 2013 оны 81 дүгээр тогтоолоор “Гудамж” төслийг хэрэгжүүлэхэд 200 сая ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн санхүүжилт олгохыг банкинд зөвшөөрсөн. Төслийн үйл ажиллагааны зардалд зориулан 0.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Одоогоор 31 уулзварын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг 9 компани гүйцэтгэхээр сонгогдсон. 2013 оны 06 дугаар сард багтаан Хяналтын зөвлөх болон Барилгын гүйцэтгэгч компанийг сонгохоор ажиллаж байна.

6 аймгийн төвийг 2013 онд хатуу хучилттай авто замаар холбох ажлын явц

	Чиглэл	Км	Гүйцэтгэлийн хувь	Тайлбар
Баянхонгор аймаг	Баянхонгор-Нарийнтээл чиглэлийн 50км хатуу хучилттай авто зам	50	98%	Барилгын ажлыг хийхээр гүйцэтгэгч ажлаа эхлүүлсэн. Талбай дээр 19 ш машин, тоног төхөөрөмж, 25 ажилчид ажиллаж байна.
	Өвөрхангай-Баянхонгор чиглэлийн 57км хатуу хучилттай авто зам	57	99%	Өөрийн шуудууны чулуун бэхэлгээ, далан, ухмалын хажуу налууг тэгшлэх, хамгаалалтын төмөр хашлага хийж байна.
	Арвайхээр-Баянхонгор чиглэлийн 50км хатуу хучилттай авто зам	50	84%	86 ажилтан, 43 машин механизм ажиллаж байна.
Дорнод аймаг	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км хатуу хучилттай авто зам	50	-	Барилгын ажил эхлээгүй байна.
	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143км хатуу хучилттай авто	143	64.7%	65 ажиллах хүч, 55 машин механизм, 39 тоног төхөөрөмж байна.
	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 95.4 км авто зам	95.4	-	4 багц замын барилгын ажил эхлээгүй. Гэрээ байгуулагдаагүй байна.
Дундговь аймаг	Улаанбаатар-Мандалговь чиглэлийн 104км хатуу хучилттай авто зам	104	18.37%	Талбайд 4 түншлэгч компаниудын 324 ажиллах хүч, 147 машин механизм ажиллаж байна
	Улаанбаатар-Мандалговь чиглэлийн 100км хатуу хучилттай авто зам	100	98%	Замын хучилтын засварын ажил хийгдэж байна
Өмнөговь аймаг	Мандалговь-Даланзадгад чиглэлийн 163км хатуу хучилттай авто зам	163	53%	Талбайд 172 ажиллах хүч, 108 машин механизм ажиллаж байна.
	Мандалговь-Даланзадгад чиглэлийн 50 км хатуу хучилттай авто зам	50	-	2 багц замын барилгын ажил эхлээгүй. Гэрээ байгуулагдаагүй байна.
	Даланзадгад-Мандалговь чиглэлийн 83 км авто зам	83	-	"Ялгуусан" ХХК-тай гэрээ байгуулсан. Улаан шугамаа хүлээж авсан.
	Мөрөн-Тариалан чиглэлийн 79км хатуу хучилттай авто зам	79	28.8%	Талбайд ажиллах хүч 133, машин механизм 60 ажиллаж байна.

Хөвсгөл аймаг	Тариалан-Мөрөн чиглэлийн 86.3 км авто зам	86.3	-	3 багц замын ажил эхлээгүй. Гэрээ байгуулагдаагүй байна.
	Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Уньт багаас Хөвсгөл аймгийн Тариалан сумын чиглэлд баригдах 88км хатуу хучилттай авто зам	88	3.2%	Талбай дээр 73 тоног төхөөрөмж ажиллаж, гадаадын 17 ажиллах хүч, дотоодын 82 ажиллах хүч байна.
Дорноговь аймаг	Чойр 35-р зөрлөгөөс Сайншанд хүртэл 176.4 км авто зам	176.4	68%	Замын барилгын ажил явагдаж байна. 2013 онд ашиглалтад өгөх боломжтой

Б. Барилгын бүтээн байгуулалт:

- 2013 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 186.3 тэрбум төгрөгийн 118 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсанаас 92 төсөл арга хэмжээ нь энэ онд шинээр хэрэгжиж эхлэхээр байна. Эдгээрээс 5 төсөл, арга хэмжээг Барилга, хот байгуулалтын яам, 56 төсөл, арга хэмжээг Худалдан авах ажиллагааны газар, 29 төсөл, арга хэмжээг Аймаг, нийслэлийн засаг дарга нарт эрх шилжүүлэн хэрэгжүүлэхээр, 3 төсөл, арга хэмжээг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраар хэрэгжүүлэхээр тус тус шийдвэрлэсэн. Барилга, хот байгуулалтын яаман дээр хэрэгжих 5 төсөл, арга хэмжээнээс гүйцэтгэгчийг шалгаруулж гэрээ байгуулсан 3, тендер зарлагдсан 1, тендерийн баримт бичгийг боловсруулж байгаа 1 төсөл, арга хэмжээ байна. Худалдан авах ажиллагааны газраар хэрэгжүүлэх 56 төсөл, арга хэмжээнээс 38 төсөл, арга хэмжээний ажлын даалгавар болон техникийн тодорхойлолтыг хүргүүлсэнээс 11 ажлын тендерийг зарлаад байна. Зураг төсөв болон техникийн тодорхойлолтыг боловсруулах шатанд байгаа 18 төсөл, арга хэмжээ байна.
- Засгийн газрын 171 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол банкны Ерөнхийлөгчтэй байгуулсан дэд хөтөлбөрийн хүрээнд Импортын гол нэрийн бүтээгдэхүүн цемент, арматур нөөцлөхөөр 80 компанид 226 тэрбум 338 сая төгрөгийн зээлийг олгохоор Барилга, хот байгуулалтын яам, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, аж ахуйн нэгжтэй гурвалсан гэрээ байгуулж Монгол банк, арилжааны банкуудад хүргүүлсэн. Барилгын материал үйлдвэрлэгчдэд эргэлтийн хөрөнгийн зээл олгох асуудлыг Ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн 67 компанид 94 тэрбум төгрөгийн зээл олгохыг дэмжиж шийдвэр гаргаж аж ахуй нэгжүүдэд хүргүүлэв.

В. Эрчим хүчний бүтээн байгуулалт:

- Засгийн газрын №35, №55-р тогтоолоор "Амгалан дулааны станц"-ыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулах хэлэлцээрт ажиллаж гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан ажлыг эхлүүлэв.
- Ухаа худаг цахилгаан станцыг Төвийн эрчим хүчний системтэй зэрэгцээ ажиллагаанд залгаж турших бэлтгэл ажилд бэлгэж сэлгэн залгалтын хөтөлбөр боловсруулан 2013 оны 04 дүгээр сарын 26 -ны өдрийн 12 цаг

41 минутанд төвийн эрчим хүчний системтэй зэрэгцээ ажиллагаанд хэвийн залгасан.

- 2013 оны 04 дүгээр сард Улаанбаатар хотын ДЦС-2 ТӨХК-аас Тк-844 хүртэлх Ф 350 мм, Ф400 мм голчтой 2130 хос магистрал шугмыг Ф700, Ф600 мм голчтой болгон өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажлыг хийж дуусгав.
- Өмнөх онуудад барилга угсралтын ажил нь эхэлсэн 2013 онд шилжин хийгдэж байгаа ажлуудын гүйцэтгэл 2010 оных 93,8 хувь, 2011 оных 84,34 хувь, 2012 оных 76 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Г. Хөдөө аж ахуйн бүтээн байгуулалт:

- 2013 онд үр тариа 324.7 мянган га-д, үүнээс улаанбуудай 313.7 мянган га-д, төмс 15.5 мянган га-д, хүнсний ногоо 7.6 мянган га-д, малын тэжээл 20.7 мянган га-д, тосны ургамал 25.0 мянган га-д, нийтдээ 393.5 мянган га-д тариалалт хийж, үр тариа 487.0 мянган тонн, үүнээс улаанбуудай 470.5 мянган тонн, төмс 208.0 мянган тонн, хүнсний ногоо 107.9 мянган тонн, малын тэжээл 51.7 мянган тонн, тосны ургамал 25.0 мянган тонныг тус тус хураан авч 330.0 мянган га-д чанар сайтай уринш бэлтгэх зорилт тавин бэлтгэл ажлыг хийж байна.
- **2013 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар 218.3 мянган га-д үр тариа, үүнээс 192.9 мянган га-д буудай, 7.2 мянгад га-д төмс, 3.0 мянган га-д хүнсний ногоо, 18.2 мянган га-д тосны ургамал, 1562 га-д тэжээлийн ургамал, нийтдээ 247.8 мянган га-д тариалалт хийгдээд байна. Улсын хэмжээнд тариалалтын явц 67,3 хувьтай байна.**
- Тариалалтад зориулан ТЭДС-д хадгалагдаж буй дотоодын буудайн үрийн үнийг 600.0 мянган төгрөгөөр тогтоож 30 хувийн урьдчилгаатай зээлээр олгохоор шийдвэрлэснээр өнөөдрийн байдлаар 76 аж ахуйн нэгж, иргэн 2100 тонн үр татан авч тариалж байна.
- Тариалалтад шаардагдах 6.3 мянган тонн, уринш боловсруулалтад 7.9 мянган тонн, ургац хураалтад 6.0 мянган тонн, нийт 20.3 мянган тонн дизелийн түлшийг тариаланчдад 50 хувийн урьдчилгаатай зээлээр олгохоор шийдвэрлэж, НИК, "Магнай трейд" ХХК-тай гэрээ байгуулан одоогийн байдлаар 450 гаруй аж ахуйн нэгж, иргэн 2200 тонн шатахуун аваад байна.
- Нөөцийн махны борлуулалт 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрөөс эхэлсэн бөгөөд 2013 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар:
 - Улаанбаатар хотын нөөцийн махны 65,2%;
 - Дархан-Уул аймагт 73.0%;
 - Орхон аймагт 82.7%-ийг тус тус борлуулаад байна.

Г. Стратегийн салбарын бүтээн байгуулалт:

- БНХАУ-ын "Чайна Ойл" компанитай байгуулсан Санамж бичгийн дагуу "Чайна-Ойл" компаниас сард 4000-10000 тонн хүртэл газрын тосны

бүтээгдэхүүн тогтмол нийлүүлэх гэрээг "НИК", "Магнай трейд", "Шунхлай" зэрэг компаниудтай байгуулсан. Тус гэрээний онцлог нь "Чайна-Ойл" компаниас нийлүүлэх бүтээгдэхүүний үнийг Монгол Улсаас БНХАУ-д экспортолж байгаа түүхий тосны үнийг суурь болгосон томъёолол дээр үндэслэсэн болно.

- Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж, бүрдүүлсэн хөрөнгөөс сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 27.7 сая ам.доллар хүртэл, хүлэмжийн аж ахуй байгуулахад 17.4 сая ам.доллар хүртэл, ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 45.0 сая ам.доллар хүртэл, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 13.5 сая ам.доллар хүртэл хөрөнгийг 4.5 жилийн хугацаатайгаар зээлээр олгох асуудлыг Засгийн газрын 141 дүгээр тогтоолоор шийдвэрлэв.
- Ашигт малтмалын газрын уул уурхайн хэлтэс, нүүрсний хэлтсээс ирүүлсэн мэдээгээр нүүрсний 52 уурхай, бусад төрлийн ашигт малтмалын 203 уурхай 2013 оны Уулын ажлын төлөвлөгөөг ирүүлсэн байна. Энэ сард 8 уурхай шинээр ашиглалтанд орсон байна.

IV. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

А. УИХ баталсан:

- Үнэт цаасны зах зээлийн тухай /Шинэчилсэн найруулга/, Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль зэрэг 14 хууль, 17 тогтоол батлагджээ.

Б.Засгийн газар баталсан:

- 2013 оны 5 дугаар сард Засгийн газар нийт 7 удаа хуралдаж, 91 асуудлыг хэлэлцэн, 28 асуудалтай танилцаж, Засгийн газрын тогтоол 42, тэмдэглэл 73, Ерөнхий сайдын захирамж 3 гарсан байна.

В.Сайд нарын баталсан:

- Яамдууд олон нийтэд хандсан захиргааны хэм хэмжээ тогтоосон 11 дүрэм, журам баталсан байна.

V. ГАДААД ХАРИЛЦАА, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ЧИГЛЭЛЭЭР:

А. Төрийн гадаад харилцаа:

- Монгол Улс Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг 2011 оны 7 дугаар сараас эхлэн 2 жил шахам хугацаанд даргалж, 2013 оны 4 дүгээр сарын 27-ноос 29-ний өдрүүдэд АОХН-ийн Сайд нарын 7 дугаар бага хурлыг эх орондоо зохион байгуулж, дарга орны албыг Эль Салвадор Улсад хүлээлгэн өгөв.
- Европын Комиссын дэд Ерөнхийлөгч бөгөөд Европын Холбооны Гадаад бодлого, аюулгүй байдлын асуудал эрхэлсэн дээд төлөөлөгч К.Эштон Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын хүрээнд Монгол Улс, ЕХ-ны хооронд Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр, Монгол Улс, ЕХ-ны хооронд "Монгол Улсын стандартчиллын тогтолцоог

боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх" тухай төслийн санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурав.

Б. Гадаадын төсөл, хөтөлбөр:

- Мэдлэг, чадвартай, хариуцлагатай, өөртөө итгэх зан үйл бүхий амьдралын ур чадвартай залуучуудыг төлөвшүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүн амын сан, Швейцарийн хөгжлийн агентлаг хамтран "Залуучуудын хөгжлийн хөтөлбөр 2013-2017" төслийг хэрэгжүүлэхээр хамтын ажиллагааны Санамж бичигт Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ, НҮБ-ын Хүн амын сангийн Суурин төлөөлөгч Аржентина Матавел нар гарын үсэг зурлаа. Төслийн хүрээнд Монголын залуучуудын зайлшгүй хэрэгцээ шаардлага болж буй Залуучуудын хөгжлийн 15 төвийг орон нутагт үе шаттайгаар байгуулна. Төслийн нийт санхүүжилт нь 11 сая ам.доллар юм.
- БШУЯ нь "Шинэ зууны боловсрол" төслийг хэрэгжүүлэх гүйцэтгэгчтэй гэрээ байгууллаа. Тус гэрээгээр "ЗТИ" корпорацтай нийт 50,328,579.0 ам долларын өртгийн бараа, ажил, үйлчилгээг 45.673.586 ам доллараар гэрээлсэн болно. Уг төсөл хэрэгжсэнээр Ерөнхий боловсролын бүх сургууль шилэн кабел бүхий өндөр хурдны сүлжээнд холбогдох бөгөөд 25000 багш зөөврийн компьютертай, 11340 сургууль компьютерийн зөөврийн лабораторитой болохоос гадна сургалтад ашиглах 2.5 сая долларын өртөгтэй "e-content"-ийн программ хангамжийг сургуулиудад нийлүүлэх юм.

VI. БАТЛАН ХАМГААЛАХЫН ЧИГЛЭЛЭЭР:

- "Цэрэг-техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр", "Цэрэг-техникийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг тус тус Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэв.
- Батлан хамгаалахын сайдын тушаалаар Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын Энхийг дэмжих /UNMISS/ ажиллагаанд үүрэг гүйцэтгэх мотобуудлагын батальон 2 дугаар ээлж, Судан Улсын Дарфур мужид явагдаж буй НҮБ-ын Энхийг дэмжих /UNMISS/ ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Цэргийн хээрийн II шатны эмнэлэгийн 4 дүгээр ээлж, Афганистан Улсад явагдаж буй Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн хамгаалалтын ротын 8 дугаар ээлж, нисдэг тэрэгний засвар үйлчилгээний бүлгийн 6 дугаар ээлжийн цэргийн багуудыг томилж, үүрэг гүйцэтгүүлэх ажлыг зохион байгууллаа.

VII. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, БОЛОВРОЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

- Төрийн өмчийн багш бэлтгэдэг их, дээд сургуулийн багш мэргэжлээр элсэгчдэд сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх, багшлах дадлагыг дэмжих зохицуулалтыг хангалаа. Төгсөөд сургууль, цэцэрлэгт 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллах үндсэн нөхцөлтэйгээр багш бэлтгэдэг төрийн өмчийн их дээд сургуульд элсэгчийг элсэлтийн ерөнхий

шалгалтад 650-750 оноо авбал сургалтын төлбөрийн 70%, түүнээс дээш оноо авбал 100% чөлөөлөх зэрэг зарчмын зохицуулалтыг тусгасан болно.

- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны 2013 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 07 тоот тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг цагт 1142.85 мөнгө байхаар шинэчлэн тогтоож энэ оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.
- АНУ-аас Монгол Улсад шилжүүлэх Тарбозавр Батаарыг 2013 оны 05 дугаар сарын 17-нд хүлээн авч, Батаарыг дэлгэж, сурталчлах ажлыг 2013 оны 06 дугаар сараас 09 дүгээр сар хүртэл зохион байгуулахаар ажиллаж байна.
- Нийслэлийн хэмжээнд төрийн өмчийн 180 цэцэрлэгийн барилга нь 32385 хүүхдийн хүчин чадалтай. Одоо цэцэрлэгүүд хүчин чадлаасаа 21107-оор (60 хувь) илүү буюу 53492 хүүхэд хүлээн авч ажиллаж байна. Нийслэлийн 152 хорооноос 18 хорооны сургуулийн өмнөх насны хүүхэд нь цэцэрлэгт 100 хувь /нийт цэцэрлэгийн 31.1 хувьд нь буюу 56 цэцэрлэгт/, 5 хорооны сургуулийн өмнөх насны хүүхдийн 80-иас дээш хувь нь цэцэрлэгт, /9 цэцэрлэгт/, 21 хорооны сургуулийн өмнөх насны хүүхдийн 50-аас дээш хувь нь цэцэрлэгт /39 цэцэрлэгт/ тус тус хамрагдаж, 67 хорооны сургуулийн өмнөх насны хүүхдийн 50 хүрэхгүй хувь нь цэцэрлэгт хамрагдсан үзүүлэлттэй байна. **Нийслэлийн хэмжээнд 41 хороо төрийн өмчийн цэцэрлэггүй байна.**

VIII. БАЙГАЛЬ ОРЧИН, МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

- Цаг уур орчны шинжилгээний газраас хиймэл дагуулын мэдээгээр Ховд аймгийн Буянт суманд 12 га талбайг хамарсан зэгс шатсан түймэр, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Асгат, Түмэнцогт суманд гарсан хээрийн түймэр, Дорнод аймгийн Чулуунхороот суманд ОХУ-аас хил давж орж ирсэн түймэрийг шуурхай тодорхойлсоор унтраав.

Анхаарах зарим асуудлууд:

- **6 аймгийн төвийг хатуу хучилттай замаар холбох ажлын явц удаашралтай байна. Одоогоор төлөвлөгөөт 281 км замын ажил эхлээгүй байна.**
- **Голлох валютын ханш (Америк доллар, БНХАУ-ын юань) сүүлийн 3 жилийн хамгийн өндөр түвшинд хүрээд байна.**
- **Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох махны үнэ тасралтгүй өсөж байна.**
- **БНХАУ-ын эдийн засгийн удаашрал, Европын Холбооны улсуудын эдийн засгийн тодорхойгүй нөхцөл байдлаас үүдэж манай экспортын гол бүтээгдэхүүн болох зэс, нүүрс, алт, төмрийн хүдрийн үнэ уналттай байна.**